

2009 оны 7-р сарын 17

Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны Сайд Ц. Нямдоржид

Эрхэмсэг Сайд Танаа:

Олон Улсын Гей Лесбиян Хүний Эрхийн Хорооны өмнөөс Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендер (ЛГБТ) Төвийг хүлээн зөвшөөрөн бүртгэхийг Танд уриалж байна. 2009 онд ЛГБТ Төв нь 10 гаруй удаа бүртгүүлэхээр өргөдлөө бүрдүүлсэн ч Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газраас ЛГБТ Төвийг бүртгэхгүй байх хэд хэдэн шалтгаан өгчээ. Үүнд: кирилл үсгээр бичсэн гадаад үгийг төрийн бус байгууллагын нэрд оруулж болохгүй, төрийн бус байгууллагын нэр “ёс суртахуунгүй байгаа тул олон нийт хүлээж авахгүй”, мөн албан ёсоор бүртгэхээс татгалзсан 6-р сарын 23-ны өдрийн захиандаа байгууллагын нэр нь “монгол зан үйл, ёс заншил, уламжлалтай зөрчилдсөн агуулгатай, залуучууд, өсвөр үеийнхэнд буруу үлгэр жишээ үзүүлэхээр байна” гэжээ. Энэхүү байгууллагын бүртгэлийг цаашид дур зоргын дагуу алагчилсан шалтгаанаар үгүйсгэсээр байх нь олон улсын хууль ба Монгол Улсын хуулийн дагуу энэхүү бүлэг хүмүүсийн хүний эрхийг зөрчсөн хэрэг юм.

Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендер Төв нь Монголын ЛГБТ олон нийтэд чиглэсэн алагчлал, мөрдлөгө хавчлага, хүчирхийллийн эсрэг нийгэм, эрх зүй болоод институцын өөрчлөлтийг бий болгохын төлөө ажиллах Монголын анхны ийм төрлийн төрийн бус байгууллага болох билээ. Энэхүү байгууллагын эрхэм зорилго нь “бэлгийн цөөнх болох эмэгтэй эрэгтэй ижил хүйстэн, бисексуал, трансжендер хүмүүсийн эрх, эрх чөлөөг хамгаалах, эрхийг баталгаажуулах, зөрчигдсөн эрхүүдийг сэргээхэд нэмэрлэх”, цаашлаад “Монгол Улсад бэлгийн цөөнхийн талаар зөв зүйтэй, бодит мэдээлэл түгээх, бэлгийн цөөнх олон нийтэд ойлголт, мэдээлэл олгох, иргэний эрх ба хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг чадварыг төлөвшүүлэх” үйл ажиллагаа явуулах юм. Сонгосон нэрээрээ бүртгүүлэх, хүний эрхийг баталгаажуулах эрхэм зорилгод нь үндэслэн энэхүү байгууллагыг бүртгэхгүй байх нь Монгол Улсаас бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанарыг үл харгалзан үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрхүүдийг зөрчсөн асуудал болно.

Бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанараар алагчлан ялгаварлан гадуурхах нь олон улсын хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөршгүй юм. Хүний Эрхийн Хороо 1994 онд Түүнэн Австралийн эсрэг хэргийг Монгол Улсын нэгдэн орсон Иргэний ба Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактын 2 ба 26 дугаар зүйлүүдийн дагуу ялгаварлан гадуурхалт, алагчлалд өртөхгүй байх хамгаалагдсан эрхийн статуст бэлгийн чиг баримжааг хамааруулна хэмээн шийдсэн байдаг. Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын томилсон Тусгай Төлөөлөгч, үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийн Тусгай Илтгэгч, Хүний Эрхийн Дээд Коммиссарын Газар, Эрүү Шүүлтийн Эсрэг Хороо гэх мэт бусад олон улсын механизмууд мөн үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх, эвлэдэн нэгдэх, хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрхийг бэлгийн чиг баримжаагаар үл алагчлан эдлүүлэх талаар улсуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байна.

Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газраас Монголын зан үйл, ёс заншил, уламжлалд харшлах, мөн залуучууд, өсвөр үеийнхэнд буруу үлгэр жишээ үзүүлэх магадлалтай гэсэн шалтгаанаар ЛГБТ Төвийг сонгосон нэрээр нь бүртгэхээс татгалзсан явдал нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаг, Иргэний ба Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт болон бусад хүний эрхийн пакт, конвенцоор баталгаажуулсан **бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанарыг үл харгалзан үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчжээ.** Энэхүү эрхийг баталгаажуулахын тулд

төрөөс ЛГБТ Төв мэт төрийн бус байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа болсон хууль эрхийн эрхээ баталгаажуулах болон хурал зөвлөлгөөн зохион байгуулах, аюулгүй бэлгийн харьцаатай холбоотой материал хэвлэх ба түүнийгээ тараах гэх мэт бусад үйл ажиллагаа явуулахад нь алагчлахгүй байх үүрэгтэй. Цаашлаад **төрөөс олон нийтийн дэг журам, ёс суртахуун, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахдаа олон төрлийн бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанарыг илтгэсэн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхэд халдан хязгаарласан, алагчилсан үйл ажиллагаа явуулахгүй байх үүрэг хүлээдэг.**

ЛГБТ Төвийг бүртгэхээс татгалзан, хууль ёсоор үйл ажиллагаагаа явуулахыг үгүйсгэх нь энэхүү байгууллагын гишүүдийн бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанарт үндэслэсэн алагчлалд өртөлгүйгээр эвлэлдэн нэгдэх, хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрхтэй хэмээн Хүний Эрхийн Түгээмэл Тунхагын 20-р зүйл, Иргэний ба Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактын 21, 22-р зүйл болон бусад хүний эрхийн гэрээ пакт, цаашлаад Хүний Эрх Хамгаалагчдын Тунхагын 1 ба 5-р зүйлүүдийг зөрчсөн байна. Олон төрлийн бэлгий чиг баримжаатай, жендерийн мөн чанартай хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжих, үүний талаар мэдээлэл түгээх, эдгээр хүмүүсийг хооронд нь холбодог **байгууллага байгуулах, түүнийгээ албан ёсоор бүртгүүлэх эрхийг нь төрөөс хангах үүрэгтэй.** Энэхүү эрхийг төрөөс олон нийтийн дэг журам, ёс суртахуун, эрүүл мэнд, аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлах ёсгүй. Мөн төрөөс **хүний эрх хамгаалагчдын хүний эрхийн төлөө үйл ажиллагаанаасаа үүдэн бүр төрлийн алагчлал болон бусад дур зоргын үйлдэлд өртөхгүй байхыг нь хангах,** олон төрлийн бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанартай хүмүүсийн эрхийг хамгаалах **хүний эрхийн байгууллагуудыг саадгүй бүртгэн дэмжиж, албан ёсоор хүлээн зөвшөөрөх ёстой.**

Олон улсын эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ гүйцэлдүүлэхийн тулд Монгол Улс ЛГБТ Төвийг Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендер Төв нэрээр нь бүртгэхийг зөвшөөрөх ёстой. ОУГЛХЭХ-оос ЛГБТ Төвийн давж заалдах хүсэлтийг нь дэмжин, үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө болон лесбиян, гей, бисексуал, трансжендер хүмүүсийг оруулан бүх Монголчуудын хүний эрхийг дээдлэн хөхиүлэн дэмжихийг Танд уриалж байна.

Гүнээ хүндэтгэсэн,

Кэри Аалан Жонсон
ОУГЛХЭХ-ны Гүйцэтгэх Захирал

СС: Хүний Эрхийн Үндэсний Комиссын Дарга Д. Солонго
Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны Төрийн Нарийн Бичгийн Дарга Г. Баясгалан
Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны Бодлого Хэрэгжилтийг Зохицуулах Газрын Дарга Т. Алтангэрэл

Олон Улсын Гей Лесбиян Хүний Эрхийн Хорооны эрхэм зорилго нь газар бүхэнд хүн бүрийн хүний эрхийг дээдлэх, бэлгийн чиг баримжаа, жендерийн мөн чанар болоод жендерийн илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, алагчлалыг дуусгавар болгоход оршино. ОУГЛХЭХ нь ашгийн бус, төрийн бус байгууллага ба Нью-Йорк хотод төвтэй, Кэйп Таун, Буэнос Айрэст салбаруудтай юм. www.iglhrc.org